

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2024 оны 12 дугаар сарын 03-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-5
<hr/>	
1.Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.12.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	4-5

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 12 дугаар сарын 03-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 46 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Д.Батбаяр, Р.Батболд, Б.Мөнхсоёл, П.Мөнхтулга, З.Мэндсайхан, Б.Чойжилсүрэн.

Нэг.Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.12.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэрүүн дэд дага Б.Солонгоо, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Г.Алтанцэцэг, мөн газрын Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Мөнгөн-Аргамж нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Ц.Даваасүрэн: 1.Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйл буюу 32¹ дүгээр зүйлийн 32¹.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“32¹.5.Энэ хуулийн 32¹.1-д заасан төсвийн төслийг Улсын Их Хурал ажлын 7 хоногт багтаан, аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дээд шатны төсвийг баталснаас хойш ажлын 5 хоногт багтаан хэлэлцэж, дараагийн төсвийн ажил эхлэхээс өмнө батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 7
Бүгд: 17

58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Ц.Даваасүрэн: 2.Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяагийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйл буюу 32¹ дүгээр зүйлийн 32¹.2, 32¹.3 дахь хэсгийн “нэгдсэн” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 0
Татгалзсан: 17
Бүгд: 17

0.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Ц.Даваасүрэн: 3.Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяагийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйл буюу 32¹ дүгээр зүйлийн 32¹.4 дэх хэсгийн “8.4, 8.5 дахь хэсэг” гэснийг “8.4, 8.5 дахь хэсэгт заасан хугацаа,” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 16
Бүгд: 17

5.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 7 минут үргэлжилж, ирвэл зохих 25 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 72.0 хувийн ирцтэйгээр 11 цаг 53 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ц.ДАВААСҮРЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ 12 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР /МЯГМАР ГАРАГ/-ИЙН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Даваасүрэн: Гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг эрье. Хуралдаанд ирвэл зохих 25-аас 13 ирсэн, 52 хувийн ирцтэй байгаа юм байна. Би ирсэн гишүүдийг танилцуулъя. Телуханы Аубакир гишүүн, Батмөнхийн Батцэцэг гишүүн, Гомбын Ганбаатар гишүүн, Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн, Ганзоригийн Тэмүүлэн гишүүн, Жигжидийн Батжаргал гишүүн, Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн, Пүрэвжавын Ганзориг гишүүн, Гонгорын Дамдинням гишүүн, Банзрагчийн Түвшин гишүүн, Дамбын Батлут гишүүн, Жамбалын Ганбаатар гишүүн, Хассуурийн Ганхуяг гишүүн, Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн нар хуралдаанд оролцож байна аа.

Хуралдааны ирц 56 хувьтай байгаа учраас 2024 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье ээ. Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя.

Нэг асуудал байна. Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн анхны хэлэлцүүлэг.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа орёе.

Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн анхны хэлэлцүүлгийг хийж эхэлье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг та бүхэнд танилцуулъя. Болдын Жавхлан Сангийн сайд, Баярсайханы Солонго ЗГХЭГ-ын тэргүүн дэд дарга Жигжидийн Ганбат Сангийн яамны ТНБД, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Зоригтбаатарын Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга гэсэн ийм улсууд оролцож байна аа. Ингээд зүйл бүрээр өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж эхэлье ээ.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна.

Нэгдүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу?

Батжаргал гишүүний санал байгаа юм байна. Би санал тус бүрээр санал хураалт явуулна. Төслийн 1 дүгээр зүйл буюу 32¹ дүгээр зүйлийн 32^{1.5} дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

32^{1.5} Энэ хуулийн 32^{1.1}-д заасан төсвийн төслийг Улсын Их Хурал ажлын 7 хоногт багтаан аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дээд шатны төсөв баталснаас хойш ажлын 5 хоногт багтаан хэлэлцэж, дараагийн төсвийн жил эхлэхээс өмнө батална. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Батжаргал.

Энэ саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 17 гишүүн оролцсон.

10 гишүүн дэмжиж 58.8 хувиар уг санал дэмжигдсэн байна.

Хоёр дахь санал төслийн 1 дүгээр зүйл буюу 32¹.1 дүгээр зүйлийн 32¹.2, 32¹.3 дахь хэсгийн нэгдсэн гэснийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Үүрийнтуяа.

Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Уг санал дэмжигдсэнгүй нэг ч гишүүн санал өгөөгүй байна.

Дараагийн саналыг 3 дахь саналыг хураалгая.

Төслийн 1 дүгээр зүйл буюу 32¹ дүгээр зүйлийн 32¹.4 дэх хэсгийн 8.4, 8.5 дахь хэсэг гэснийг 8.4, 8.5 дахь хэсэгт заасан хугацаа гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Үүрийнтуяа. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 17 гишүүн оролцож нэг гишүүн дэмжиж, уг санал дэмжигдсэнгүй ээ.

Өөр санал байна уу? 1 дүгээр зүйл дээр.

Ингээд санал хураалтыг явуулж дууслаа.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу?

2 дугаар зүйл байна уу? Алга байна. Зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? 2 дугаар зүйлээр. Алга байна. Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Заяабал гишүүн танилцуулна. Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдааныг хаасныг мэдэгдье ээ. Гишүүдэд баярлалаа.

11.53 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА